



**ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН
ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ**
(Эрүүгийн хэрэг)¹

**ШҮҮГДЭГЧИД АШИГТАЙ ПОЛИГРАФИЙН ДҮГНЭЛТИЙГ
ШҮҮХ НОТЛОХ БАРИМТААР АШИГЛАНА**

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: AG Bautzen, 26.10.2017 - 42 Ds 610 Js 411/15
jug

Шүүхийн шийдвэрийн огноо: 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Шийдвэрийн төлөв байдал: Анхан шатны шүүх шүүгдэгчийг цагаатгасан

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өөрийн төрсөн ахын дагавар охин болох 9 настай С-тэй хамт кино үзэж байхдаа бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн² гэх гэмт хэрэгт холбогдсон ч гэм буруугаа хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд полиграф³ (*гер. Polygrafentest*)-ийн шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Орон нутгийн шүүхээс хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэн шүүгдэгчийг цагаатгажээ. Шүүх шийдвэрийн үндэслэлдээ хохирогч С-ийн мэдүүлэг илт зөрүүтэй байснаар эргэлзээ үүссэн. Уг эргэлзээтэй байдлыг хохирогчийн мэдүүлэгт хийсэн шинжээчийн дүгнэлтээр баталгаажуулсан. Мөн шүүгдэгчийн сайн дурын зөвшөөрлийн үндсэн дээр хийсэн полиграф шинжилгээний дүгнэлтээр шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн эсэхэд эргэлзээтэй байдал бий болсныг баталсан гэжээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт тус улсын шүүхийн практикт полиграф ашиглах асуудал маргаантай хэвээр байгаа мөн эрүүгийн хэрэгт полиграф

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос <https://dejure.org/dienste/vernetzung/rechtsprechung?Gericht=AG%20Bautzen&Datum=26.10.2017&Aktenzeichen=42%20Ds%20610%20Js%20411%2F15>, Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

² Эрүүгийн хуулийн 176 дугаар зүйл. Хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үзүүлэх “арван дөрвөөс доош насны хүнд бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн эсвэл тухайн хүүхдийг өөртэйгөө бэлгийн харилцаанд оруулахад хүргэсэн бол зургаан сараас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”. Strafgesetzbuch (StGB), 1871, <https://www.gesetze-im-internet.de/stgb/BJNR001270871.html#BJNR001270871BJNG000102307>, (Сүүлд үзсэн: 2024.12.12).

³ “Хүний сэтгэц физиологийн хариу урвалыг тусгай багажийн тусламжтайгаар бүртгэн авч, харьцуулан шинжлэх зориулалт бүхий төхөөрөмж”. Ж.Болдбаатар, Гэмт хэрэг илрүүлэхэд полиграф ашиглах онол, арга зүйн асуудал, Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл, 2013, 8 дахь тал.



шинжилгээний дүгнэлтийг ашиглах нь Үндсэн хууль болон Эрүүгийн процессын хуулийг зөрчсөн гэж шийдвэрлэж буй шүүхийн практик байгааг дурджээ.

Тухайлбал, полиграф ашиглах нь сэжигтний чөлөөт хүсэл зоригт нөлөөлдөг гэж үздэг учраас энэ арга нь Эрүүгийн процессын хуульд заасан мэдүүлэг авах хориглосон аргад хамаардаг, цаашлаад хориглосон аргаар мэдүүлэг авах нь Үндсэн хуульд заасан хүний нэр төр халдашгүй байна гэснийг зөрчсөн хэмээн Холбооны Улсын дээд шүүхээс 1954 оны шийдвэртээ дурдсан байна.⁴ Мөн Үндсэн хуулийн шүүхээс полиграф ашиглах нь Үндсэн хуультай зөрчилдсөн гэж үзэхийн сацуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн бодит байдлыг тогтоох үүргийг шүүх хүлээх бөгөөд шүүх полиграф ашиглахгүйгээр уг үүргээ биелүүлэх ёстой гэсэн шийдвэрийг 1981 онд гаргаж байжээ.⁵

Үүний дараа Холбооны Улсын дээд шүүхээс 1998 онд шийдвэрлэсэн шийдвэртээ полиграф ашиглах нь Үндсэн хууль болон Эрүүгийн процессын хуультай зөрчилдөөгүй, гэхдээ нотлох баримтын шинжийг хангахгүй⁶ хэмээн үзсэн бөгөөд орон нутгийн шүүхээс уг хэргийг шийдвэрлэхдээ Холбооны Улсын дээд шүүхийн 1998 оны шүүхийн шийдвэрийг дурдаж, үндэслэлдээ дараах тайлбарыг хийжээ.

Үндсэн хууль⁷-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүний нэр төр халдашгүй байна хэмээн заасан бөгөөд уг зохицуулалт хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан бус, хамгаалсан зохицуулалт. Тиймээс **шүүгдэгчийн сайн дурын зөвшөөрлийн үндсэн дээр** полиграф шинжилгээ хийсэн нь Үндсэн хуультай зөрчилдөхгүй.

Полиграф ашиглан мэдүүлэг авсныг Эрүүгийн процессын хууль⁸-ийн 136а дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль бус аргаар мэдүүлэг авсан гэж үзэхгүй. Хэрэв полиграф ашиглан мэдүүлэг авсныг хууль бус аргаар мэдүүлэг авсан гэж үзэх тохиолдолд шүүгдэгчийн сайн дурын зөвшөөрлийн үндсэн дээр уг ажиллагааг явуулсан ч шүүх тухайн мэдүүлгийг нотлох баримтаар ашиглах боломжгүйд хүрнэ. Учир нь Эрүүгийн процессын хуулийн 136а дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хууль бус аргаар мэдүүлэг авсан тохиолдолд сэжигтэн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран шүүх уг баримтыг нотлох баримтаар ашиглахгүй хэмээн заасан байна. Уг зохицуулалт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчийн эрх мэдлийг хязгаарласан зохицуулалт учраас төсөөтэй хэрэглэхийг хориглодог. Иймд сэжигтний сайн дурын зөвшөөрлийн үндсэн дээр полиграф ашигласан тохиолдолд хууль бус аргаар мэдүүлэг авсан гэж үзэхгүй бөгөөд Эрүүгийн процессын хуулийн 136а дугаар зүйлийн 3-т заасныг төсөөтэй хэрэглэхгүй.

⁴ BGH vom 16. 2. 1954 zur AZ 1 StR 578/53.

⁵ BVerfG vom 18. 8. 1981 zur AZ 2 BvR 166/81.

⁶ BGH vom 17. 12. 1998 zur AZ 1 StR 156/98.

⁷ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, 1949. <https://www.gesetze-im-internet.de/gg/index.html>, (Сүүлд үзсэн: 2024.12.12).

⁸ Strafprozeßordnung (StPO), 1950, <https://www.gesetze-im-internet.de/stpo/index.html>, (Сүүлд үзсэн: 2024.12.12).



Мөн шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт полиграф ашиглах нөхцөлд өндөр шаардлага тавих ёстой гээд **дараах урьдчилсан нөхцөл хангагдсан тохиолдолд** шүүгдэгчид ашигтай прографийн үр дүнг шүүх нотлох баримтаар ашиглана гэж үзсэн байна. Үүнд:

- a) Шүүгдэгчийн сайн дурын зөвшөөрлөөр,
- b) Шүүхийн эсвэл прокурорын шийдвэрийн үндсэн дээр,
- c) Шинжилгээг лабораторийн орчинд мэргэжлийн шинжээчийн удирдлага доор хамгийн багадаа дөрвөн хэмжүүр үзүүлэлтийг (*цусны даралтын хэлбэлзэл, амьсгал, арьсны цахилгаан дамжуулах хариу урвал, судасны цохилт*) ашиглан явуулах,
- d) Хэрэгт хамааралтай асуулт асуух,
- e) Полиграфийн шинжилгээний дүгнэлтийг зөвхөн шүүгдэгчид ашигтай тохиолдолд шүүх үнэлэх.

Шүүгдэгчийн сайн дурын зөвшөөрлийн үндсэн дээр явуулсан полиграф нь дээрх урьдчилсан нөхцөлүүдийг хангасан учраас шүүх шүүгдэгчид ашигтайгаар гарсан полиграфийн шинжилгээний дүгнэлтийг нотлох баримтаар үнэлэн шүүгдэгчийг цагаатгажээ.

---o0o---